| 7. | Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил<br><br>Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох)<br><input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч |
| 8. | Хавсралт<br><br>- Гэрээний хуулбар<br>- Гэрээ дүгнэсэн акт / бараа хүлээлцсэн акт / захиалагчийн тодорхойлолт  |

## **VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ**

### **Санамж**

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж бараа худалдан авахад энэхүү гэрээний нөхцөлийг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас бараа, түүнтэй холбогдох үйлчилгээг худалдан авах харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн бараа худалдан авах нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:

1. ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн бараа худалдан авахад хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;
2. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
3. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
4. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
5. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
6. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтан дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. ГТН-д заасан зарим жишээ, нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.

## VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

### ГАРЧИГ

|   |    |
|---|----|
| ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ .....                                       | 1  |
| НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР .....                                  | 1  |
| Тодорхойлолт .....  | 1  |
| Гэрээний тайлбар .....  | 2  |
| ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ .....  | 2  |
| Бараа нийлүүлэх .....   | 2  |
| Бараа нийлүүлэх газар .....   | 3  |
| Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах .....                       | 3  |
| Барааг хүлээнэгэн өгөх .....  | 3  |
| Барааны гарал үүслийн улс .....                                     | 3  |
| Баглаа боодол .....   | 3  |
| Худалдааны нөхцөл .....   | 4  |
| Гүйцэтгэлийн баталгаа .....   | 4  |
| ГУРАВ. ЗАХИАЛАГЧ .....  | 4  |
| Барааг хүлээн авах .....  | 4  |
| Шалгалт, туршилт .....  | 4  |
| Гэрээний үнэ .....  | 5  |
| Төлбөр төлөх .....  | 5  |
| ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА .....                                   | 5  |
| Захиалагчийн хүлээх эрсдэл .....                                    | 5  |
| Даатгал .....   | 5  |
| Доголдол .....  | 6  |
| Чанарын баталгаа .....  | 6  |
| Алданги .....   | 6  |
| Оюуны өмчийн эрх зөрчих .....                                       | 7  |
| Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал ..... | 7  |
| Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа .....                             | 7  |
| ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ .....                                    | 7  |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл .....                   | 7  |
| Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэл .....                   | 8  |
| ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ .....  | 8  |
| Төлөөлөгч .....   | 8  |
| Туслан гүйцэтгэгч .....   | 8  |
| Нууцлал .....   | 8  |
| Мэдэгдэл .....  | 9  |
| Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах .....                              | 9  |
| Маргаан шийдвэрлэх .....  | 9  |
| ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ .....  | 10 |
| ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ .....                                    | 12 |

# ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

### Тодорхойлолт

- 1.1. Гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл нь дор дурдсан утгыг агуулна:
  - 1.1.1. “Бараа” гэж Нийлүүлэгчээс Захиалагчид нийлүүлэхээр Тендерт ирүүлсэн хөрөнгийг;
  - 1.1.2. “Дагалдах үйлчилгээ” гэж бараа нийлүүлэхтэй холбоотой угсралт, суурилуулалт, сургалт, засвар үйлчилгээ болон Нийлүүлэгчийн үзүүлэх бусад үйлчилгээг;
  - 1.1.3. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.4. “Нийлүүлэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
  - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Нийлүүлэгчийг хамтад нэрлэснийг;
  - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
  - 1.1.7. “Бараа нийлүүлэх нөхцөл” гэж Захиалагчийн техникийн тодорхойлолтод нийцүүлж Тендерт тусгасан бараа бэлтгэх, нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг ойлгоно. Тендерт тусгайлан заагаагүй бараа нийлүүлэх нөхцөлийг Техникийн тодорхойлолтод тусгаснаар ойлгоно. Хуулийн 30.2, 34.2-т зааснаар хэлэлцээ хийсэн тохиролцоо нь Гэрээнд тусгагдсан бол Бараа нийлүүлэх нөхцөлийн нэг хэсэг болно.
  - 1.1.8. “Бараа нийлүүлэх газар” гэж барааг хүлээлгэн өгөх болон дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг;
  - 1.1.9. “Доголдол” гэж нийлүүлсэн бараа, дагалдах үйлчилгээний барааны шинж байдал, чанар тоо хэмжээ нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерээс зөрүүтэй байхыг;
  - 1.1.10. “Баталгаат хугацаа” гэж нийлүүлсэн барааг зориулалтын дагуу ердийн байдлаар ашиглах явцад бараанд илэрсэн доголдлыг нийлүүлэгч хариуцах хугацааг;
  - 1.1.11. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж гэрээгээр баталгаат хугацаа тогтоогоогүй бол Захиалагчаас доголдолтой холбогдуулж Нийлүүлэгчид шаардлага гаргах хугацааг;
  - 1.1.12. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Нийлүүлэгчтэй

- харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
- 1.1.13. “Нийлүүлэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах, гэрээнээс татгалзахаас бусад Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Нийлүүлэгчээс томилогдсон этгээдийг;
- 1.1.14. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.
- Гэрээний тайлбар**
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
- 1.2.1. Ганц тоог илэрхийлсэн үг нь олон тоог, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоог хамааруулж болно.
- 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
- 1.2.3. Зүйл, заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томьёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад үндэслэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
- 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
- 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.
- ХОЁР. НИЙЛҮҮЛЭГЧ**
- Бараа нийлүүлэх**
- 2.1. Нийлүүлэгч нь гэрээнд заасан бараа нийлүүлэх нөхцөл, нийлүүлэлтийн хуваарь, ГТН-д заасан хугацааг баримтлан Бараа нийлүүлэх, Дагалдах үйлчилгээ үзүүлэх үүрэгтэй.
- 2.2. Нийлүүлэгч гэрээний дагуу Дагалдах үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай ажилтан, тоног төхөөрөмж зэргийг Тендерт санал болгосноор оролцуулах ба гүйцэтгэлийн явцад эдгээрт өөрчлөлт орох зайлшгүй

- шардлагатай нөхцөл үүссэн бол Захиалагчаас урьчилан бичгээр зөвшөөрөл авна.
- 2.3. ГЕН-ийн 2.2-т заасны дагуу өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн шардсан техникийн чадавх, туршлагын шардлагыг хангасан байна.
  - 2.4. Нийлүүлэгч нь Барааг нийлүүлэхэд зайлшгүй шардлагатай баримт бичиг, бусад зүйлийг гаргуулахыг хүссэн тохиолдолд Захиалагч ердийн боломжит хугацаанд гаргаж өгнө.
- Бараа нийлүүлэх газар**
- 2.5. Бараа нийлүүлэх болон Дагалдах үйлчилгээ үзүүлэх газрыг ГТН-д заана.
- Бараа нийлүүлэх хугацаа, түүнийг сунгах**
- 2.6. Бараа нийлүүлэх хугацааг нийлүүлэлтийн хуваарийг үндэслэн ГТН-д заана.
  - 2.7. Нийлүүлэгч дараах нөхцөл бий болсон тохиолдолд бараа нийлүүлэлтийн хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
    - 2.7.1. Захиалагч ГЕН-ийн 2.4-д заасан үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
    - 2.7.2. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон.
  - 2.8. Захиалагч ГЕН-ийн 2.7-д заасан нөхцөлийн аль нэг нь бүрдсэн гэж үзвэл Нийлүүлэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
  - 2.9. ГЕН-ийн 2.7.2-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Нийлүүлэгч нотлох үүрэгтэй.
- Барааг хүлээлгэн өгөх**
- 2.10. Нийлүүлэгч нь Барааг ГТН-д заасан нөхцөлөөр хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг бүрэн үзүүлж, баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
  - 2.11. Нийлүүлэгч нь барааг хүлээлгэн өгч, дагалдах үйлчилгээг үзүүлснээр Захиалагчид барааны өмчлөх эрх шилжинэ.
- Барааны гарал үүслийн улс**
- 2.12. Гэрээний дагуу нийлүүлэх Бараа нь Тендерт заасан улсын гарал үүсэлтэй байна.
  - 2.13. Нийлүүлэгчийн Тендерийг шалгаруулахад түүнд давуу эрх олгосон бол үнэлгээний явцад үнийг нь хийсвэрээр бууруулж тооцсон аливаа бараа нь заавал Монгол Улсын гарал үүсэлтэй бараа байна.
- Баглаа боодол**
- 2.14. Нийлүүлэгч барааг ГЕН-ийн 2.5-д заасан газар хүртэл тээвэрлэх явцад гэмтэх, муудах, дутах зэрэг доголдоос урьчилан сэргийлэх сав, баглаа боодлыг ГТН-д заасны дагуу хангана.
  - 2.15. Сав, баглаа боодол, түүний хаягдал нь хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг хамгийн бага байхаар сонгоно. Сав, баглаа боодолд хууль тогтоомжоор хориглосон материал ашиглахыг хориглоно.

- 2.16. Нийлүүлэгч баглаа боодол, түүний дотор, гадна талд тэмдэглэгээ хийх, баримт бичгийг бэлтгэхдээ ГТН-д заасан шаардлага болон Захиалагчийн тухайн үед өгөх зааварчилгааг мөрдөнө.
- Худалдааны нөхцөл**
- 2.17. Гэрээнд Худалдааны нөхцөл (Incoterms)-ийг хэрэглэх бол тендерийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ-ны 20.6-д заасан нөхцөлийг ГТН-д тусгана.
- 2.18. ГТН-д заагаагүй бол Incoterms 2020 Delivery Duty Paid /DDP/ нөхцөлөөр бараа нийлүүлэлтийн хуваарьт дурдсан газарт хүргүүлэхээр хэрэглэнэ.
- Гүйцэтгэлийн баталгаа**
- 2.19. Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар ТӨХ-д заасан бол Нийлүүлэгч нь гэрээний үнийн 5 хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.
- 2.20. Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Нийлүүлэгчийн Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангулна:
- 2.20.1. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
  - 2.20.2. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
  - 2.20.3. Нийлүүлэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
- 2.21. Захиалагч гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангулсан нь Нийлүүлэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй.
- 2.22. ГЕН-ийн 2.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Нийлүүлэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна.
- 2.23. Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 4.11-д заасан Чанарын баталгаа гаргасан тохиолдолд Гүйцэтгэлийг баталгааг чөлөөлнө.
- ГУРАВ. ЗАХИАЛАГЧ**
- Барааг хүлээн авах**
- 3.1. Захиалагч нь барааг хүлээн авч, хүлээлцсэн баримт (хүлээлцсэн акт) үйлдэнэ.
- Шалгалт, туршилт**
- 3.2. Нийлүүлэх бараа, дагалдах үйлчилгээ, үйлдвэрлэлийн үйл явц Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт нийцэж буй эсэхийг хянах зорилгоор Захиалагч шалгалт, туршилт явуулах эрхтэй. Шалгалт, туршилт хийх хугацаа, журмын талаар Захиалагч нь Нийлүүлэгчид бичгээр урьдчилан мэдэгдэнэ.
- 3.3. Шалгалт, туршилтын явцыг тэмдэглэл үйлдэн талууд баталгаажуулах бөгөөд бараа, дагалдах үйлчилгээ доголдолтой тохиолдолд Захиалагч доголдлыг арилгуулахаар Нийлүүлэгчид мэдэгдэл хүргүүлнэ.

- 3.4. ГЕН-ийн 3.3-т заасан мэдэгдлийн дагуу Нийлүүлэгч барааны доголдлыг арилгах арга хэмжээ авна.
- 3.5. Барааг хүлээн авахаас өмнө Захиалагч шалгасан, туршсан байх нь хүлээн авах үед түүнийг дахин шалгах, турших болон шаардлагатай тохиолдолд барааг хүлээн авахаас татгалзах, доголдолтой холбогдуулж шаардлага гаргах Захиалагчийн эрхийг хязгаарлахгүй.
- 3.6. Шалгалт, туршилт хийхтэй холбоотой аливаа зардлыг Нийлүүлэгч хариуцна.
- Гэрээний үнэ**
- 3.7. Гэрээний үнийг Гэрээ баталгаажуулах маягтад заана.
- 3.8. Гэрээний үнэд хуулийн 40.4-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д заана.
- Төлбөр төлөх**
- 3.9. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг Нийлүүлэгчид төлнө.
- 3.10. Нийлүүлэгчийн хүсэлтээр Захиалагч Бараа нийлүүлэх хугацааг ГЕН-ийн 2.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
- 3.11. Захиалагч нь гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон бусад холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
- 3.12. Захиалагч урьдчилгаа төлбөр төлөхгүй.
- 3.13. ГЕН-ийн 3.8-д заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
- 3.14. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
- 3.15. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Нийлүүлэгчид төлөх төлбөрөөс суутгана.
- ДӨРӨВ. ЭРСДЭЛ БА ХАРИУЦЛАГА**
- Захиалагчийн хүлээх эрсдэл**
- 4.1. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:
- 4.1.1. Барааг захиалагчид шилжүүлснээс хойш бараа нь ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар гэмтсэн, устсан;
- 4.1.2. Нийлүүлэгч Барааг гэрээнд заасан хугацаанд хүлээлгэн өгөх тодорхой үйлдэл хийсэн боловч Захиалагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүлээн аваагүй (доголдолтой бараанд хамаарахгүй) байх хугацаанд ГЕН-ийн 1.1.14-д заасан болон бусад байдлаар Бараа гэмтсэн, устсан.
- Даатгал**
- 4.2. Нийлүүлэгч нь барааг үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, хүлээлгэн өгөх үед гарч болох эрсдэлээс

- хамгаалж ГТН-д заасны дагуу даатгуулж, даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг Захиалагчид ирүүлнэ. Даатгалын хураамжийг Нийлүүлэгч хариуцна.
- Доголдол**
- 4.3. Захиалагч бараа, дагалдах үйлчилгээг шалгаж, илэрсэн зөрчил, доголдлын талаар Нийлүүлэгчид мэдэгдэнэ.
  - 4.4. Захиалагч зөрчил, доголдлыг илрүүлэх зорилгоор барааны далд хэсгийг нээх, шалгалт, туршилт хийх эрхтэй.
  - 4.5. Захиалагч ГТН-д заасан баталгаат хугацаа эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг нийлүүлэгчид өгнө.
  - 4.6. Доголдол арилгах мэдэгдэл өгсөн тухай бүр Нийлүүлэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана.
  - 4.7. Нийлүүлэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгана.
  - 4.8. Захиалагчийн гаргасан зардлыг Нийлүүлэгч Захиалагчид үл маргах журмаар төлнө.
  - 4.9. Захиалагч нь ГЕН-ийн 4.7-д заасан зардлыг Чанарын баталгаанаас суутгаж болох бөгөөд Чанарын баталгаа хүрэлцээгүй тохиолдолд илүү гарсан зардлыг Нийлүүлэгч нь Захиалагчид үл маргах журмаар төлнө.
  - 4.10. Бараа, дагалдах үйлчилгээний баталгаат хугацааг ГТН-д заана.
  - 4.11. ГТН-д заасан бол чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно.
  - 4.12. Нийлүүлэгч Чанарын баталгааг хуулийн 43.7-д заасны дагуу баталгаажуулж болно.
  - 4.13. ГЕН-ийн 4.12-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно.
  - 4.14. Баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаанд Бараанд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө.
  - 4.15. ГЕН-ийн 4.7-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Нийлүүлэгчид олгоно.
  - 4.16. ГЕН-ийн 4.7-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат эсхүл гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ.
  - 4.17. Нийлүүлэгч нь барааг хуваарийн дагуу буюу гэрээнд заасан хугацаанд нийлүүлээгүй тохиолдолд хугацаа
- Алданги**

|  |   |
|--|---|
|  | хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.  |
| <b>Оюуны өмчийн эрх зөрчих</b>                                       | 4.18. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Нийлүүлэгчид төлнө.  |
| <b>Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал</b> | 4.19. Барааг өмчлөх, эзэмших, ашиглах явцад гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.   |
| <b>Үүрэг гүйцэтгүүлэх нэмэлт хугацаа</b>                             | 4.20. Барааг гэрээнд заасан хугацаанд нийлүүлэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Нийлүүлэгч нь энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 6.10-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.<br>4.21. Нийлүүлэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.<br>4.22. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцэж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.<br>4.23. Гэрээг хэрэгжүүлэх Захиалагчийн зааварчилгаа, Нийлүүлэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Нийлүүлэгч ГЕН-ийн 2.7-д заасан хүсэлт гаргаж болно.<br>4.24. Гэрээний нэг тал нь үүргийн зөрчил гаргасан тохиолдолд нөгөө талд үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоож, мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.<br>4.25. Иргэний хуулийн 226 дугаар зүйлд заасан үндэслэл бий болсон тохиолдолд эсхүл Нийлүүлэгч ГЕН-ийн 2.13-т заасныг зөрчсөн бол нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно. |
|  | <b>ТАВ. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ</b>   |
| <b>Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах үндэслэл</b>                   | 5.1. Захиалагч дараах үндэслэлийн аль нэг нь хангагдсан тохиолдолд гэрээнээс татгалзах эсхүл гэрээг цуцлах эрхтэй:<br>5.1.1. Нийлүүлэгч гэрээнд заасан хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл зохих ёсоор гүйцэтгээгүйн улмаас Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоосон боловч нэмэлт хугацаанд гүйцэтгээгүй;<br>5.1.2. Бараа нийлүүлэх хугацаанд Нийлүүлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн  |

|  |        |   |
|--|--------|---|
|  |        | хугацаа дуусч сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон;   |
|  | 5.1.3. | Нийлүүлэгч ГЕН-ийн 6.5-д заасан үүргээ зөрчсөн нь тогтоогдсон.  |
| 5.2.   |        | Нийлүүлэгч тендерт оролцох буюу бараа нийлүүлэх явцдаа авилгал, залилан мэхлэх гэмт хэрэг үйлдсэн нь шүүх болон эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон.  |
| 5.3.   |        | Захиалагч нь төлбөр хийх хугацаа хэтэрсэн тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш тогтоосон хугацаанд төлбөрийг төлөөгүй тохиолдолд Нийлүүлэгч гэрээг цуцалж болно.  |
| 5.4.   |        | Нийлүүлэгч ямар ч тохиолдолд гэрээнээс татгалзах эрхийг хэрэгжүүлэхгүй.   |
| Гэрээнээс татгалзах,<br>гэрээг цуцлах мэдэгдэл | 5.5.   | Гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах мэдэгдэлд гэрээнээс татгалзах, гэрээг цуцлах болсон үндэслэл, цашид гэрээг дуусгавар болсонтой холбоотой авах арга хэмжээний тухай тусгасан байна.   |
|  |        | <b>ЗУРГАА. БУСАД ЗҮЙЛ</b>   |
| Төлөөлөгч                                      | 6.1.   | Талууд өөрийн төлөөлөгчийг томилж, томилсон төлөөлөгчийн мэдээллийг гэрээ баталгаажуулах маягтад заана.   |
|  | 6.2.   | Төлөөлөгчийн мэдээлэлд түүний эцэг (эх)-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаяг тэмдэглэгдсэн байна.   |
|  | 6.3.   | Гэрээ хэрэгжүүлэх явцад төлөөлөгч солигдсон бол Төлөөлөгч солигдсон тухай болон түүний мэдээллийг агуулсан мэдэгдлийг нөгөө талд бичгээр хүргүүлнэ.   |
|  | 6.4.   | Төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.   |
| Туслан гүйцэтгэгч                              | 6.5.   | Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлж байгаа тохиолдолд Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерт зааснаас илүү хувийг туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.  |
|  | 6.6.   | Туслан гүйцэтгэгчийн аливаа зөрчлийг (хугацаа хэтрүүлэх, ажлын доголдол гэх мэт) Нийлүүлэгч хариуцах бөгөөд Туслан гүйцэтгэгч өөрчлөгдсөн тохиолдолд ГЕН-ийн 2.3-д заасан журмыг баримтална.  |
| Нууцлал  | 6.7.   | Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бүхий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй. |
|  | 6.8.   | Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл  |

|   |   |
|---|---|
|   | хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийг хамт өгнө.  |
| <b>Мэдэгдэл</b>                         | <p>6.9. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.</p> <p>6.10. Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн тухай мэдэгдлийг ГЕН-ийн 6.9 -д зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.</p> <p>6.11. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан Төлөөлөгчийн хаягаар илгээнэ.</p> <p>6.12. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:</p> <p>6.12.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр, төлбөр төлсөн баримтыг үндэслэн;</p> <p>6.12.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.</p> <p>6.13. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.</p> <p>6.14. ГЕН-ийн 6.13-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.</p> <p>6.15. Дараах тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулна:</p> <p>6.15.1. ГЕН-ийн 2.8-т заасны дагуу хугацаа сунгагдсан;</p> <p>6.15.2. үнийн тохируулга хийсэн.</p> <p>6.16. Гэрээний нэмэлт, өөрчлөлтөд талуудын эрх бүхий төлөөлөгч гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.</p> <p>6.17. ГЕН-ийн 6.15-д зааснаас бусад тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй.</p> <p>6.18. Гэрээг биелүүлэхтэй холбогдон гарсан аливаа санал зөрөлдөөн, маргааныг талууд зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.</p> <p>6.19. Талууд зөвшилцөн, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.</p> |
| <b>Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах</b> |   |
| <b>Маргаан шийдвэрлэх</b>               |   |

## ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

|                  |   |
|------------------|---|
| <b>ГЕН 2.5.</b>  | Бараа нийлүүлэх газар:<br><b>Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв</b>   |
| <b>ГЕН 2.6.</b>  | Бараа нийлүүлэх хугацаа: 2023 оны 03 сар<br><br>Барааг үе шаттай нийлүүлэх бол үе шатны хугацаа:<br><b>Нийлүүлэлтийн хуваарь дагуу</b>  |
| <b>ГЕН 2.10.</b> | Бараа хүлээлгэн өгөх нөхцөл:<br><b>Талууд барааг биечлэн хүлээлцэнэ.</b><br>Бараанд холбогдох баримт бичиг: <b>зарлагын баримт</b>  |
| <b>ГЕН 2.14.</b> | Баглаа, боодол:<br><b>Эм, эмнэлгийн хэрэгслийг хадгалах, тээвэрлэхэд шаардагдах стандарт нөхцлийн дагуу</b>   |
| <b>ГЕН 2.17.</b> | Худалдааны нөхцөл:<br><b>Худалдааны нөхцөл (Incoterms 2020-би дагуу)</b>  |
| <b>ГЕН 3.8.</b>  | Үнийн тохируулга хийх аргачлал:<br><b>Үнийн тохируулга хийхгүй</b>  |
| <b>ГЕН 3.9.</b>  | Төлбөр төлөх хугацаа:<br><br>Гадаад валютаар хийх төлбөр нь бэлэн бус байдлаар төлөгдөнө:<br><b>1.Урьдчилгаа төлбөр:</b> Урьдчилгаа төлбөр хийхгүй<br><b>2.Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</b> Бараа ачигдсаны дараа төлбөр хийхгүй.<br><b>3.Барааг хүлээн авахад төлөх:</b> Ирсэн барааны гэрээний үнийн дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.<br><br>Төгрөгөөр хийх төлбөр нь нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай акт ирснээс хойш 30 хоногийн дотор төлөгдөнө.<br><br><b>Монгол улсын дотроос санал болгосон барааны төлбөр:</b><br>Монгол улсын дотроос нийлүүлсэн барааны төлбөр нь дараах байдлаар хийгдэнэ. Үүнд:<br><b>1.Урьдчилгаа төлбөр:</b> Урьдчилгаа төлбөр хийхгүй<br><b>2.Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</b> Бараа ачигдсаны дараа төлбөр хийхгүй. |

|                  |   |
|------------------|---|
|                  | <p><b>3.Барааг хүлээн авахад төлөх:</b> Ирсэн барааны гэрээний үнийн дүнг бараа ирснээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлнө.</p> <p>Төгрөгөөр хийх төлбөр нь нэхэмжлэх (Захиалагчийн нэр, хаягийг бичиж, барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан, гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан байна) болон захиалагчийн бараа хүлээн авсан тухай акт ирснээс хойш 30 хоногийн дотор төлөгднө.</p>   |
| <b>ГЕН 4.2.</b>  | <p>Даатгал:</p> <p><i>[Даатгалын нөхцөлийг тухайн бараа нийлүүлэлтийн онцлог болон худалдааны нөхцөлүүдийг харгалзан тодорхойлно. Даатгалын төрөл заах]</i></p>   |
| <b>ГЕН 4.10.</b> | <p>Баталгаат хугацаа:</p> <p><i>[Баталгаат хугацаа заасан эсэх, заасан бол Тендерийн баримт бичигт үндэслэн хугацааг тогтоож бичих]</i></p>   |
| <b>ГЕН 4.11</b>  | <p>Чанарын баталгаа:</p> <p><i>Чанарын баталгаа шаардах эсэх: Чанарын баталгаа шаардана.</i></p> <p><i>Гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа нь шинэ үйлдвэрлэгдсэн, өмнө ашиглагдаагүй бөгөөд үйлдвэрлэсэн болон хүчинтэй байх хугацааг хангасан байна. ГТН-д өөрөөр заагаагүй бол гэрээний дагуу нийлүүлэгдэх бараа, үйлчилгээ нь нийлүүлэгдэх үед 2 жилээс дээш хадгалалтын хугацаатай барааны (5/6) нь өнгөрөөгүй, 2 ба түүнээс доош хадгалалтын хугацаатай барааны хувьд (3/4) нь өнгөрөөгүй болохыг нийлүүлэгч баталгаажуулна.</i></p> <p><i>Мөн гэмтэл согоггүй бөгөөд гэрээний нөхцөлүүд болон техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн, эрх бүхий байгууллагаас чанарын шаардлага хангаагүй үндэслэлээр хэрэглээнээс хасагдаагүй, орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.</i></p> <p>Чанарын баталгааны дүн: <i>Гэрээний үнийн дүнгийн 5 хувь байхаар бичих</i></p> |
| <b>ГЕН 4.17.</b> | <p>Нийлүүлэгчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: “<i>Тийм</i>”</p> <p>Алдангийн хувь: <i>хоног тутамд 0.05 хувиас хэтрэхгүй, суутгах дээд хэмжээ нь 0,5 хувиас хэтрэхгүй байна.</i></p>  |
| <b>ГЕН 4.18.</b> | <p>Захиалагчийн төлөх алданги:</p> <p>Алданги тооцох эсэх: “<i>Тийм</i>”</p> <p>Алдангийн хувь: <i>хоног тутамд 0.05 хувиас хэтрэхгүй, суутгах дээд хэмжээ нь 0,5 хувиас хэтрэхгүй байна.</i></p>   |

## ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.  
Дугаар № [Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэрийг бичих] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэрийг бичих] (цаашид “нийлүүлэгч” гэх) нь Нийлүүлэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Нийлүүлэгчийн хооронд бараа нийлүүлэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Бараа” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу нийлүүлэх Барааны үнэ нь [гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих] төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Нийлүүлэгч [Нийлүүлэгчийн нэрийг бичих]-ийн харилцах [Банкны нэрийг бичих] банкны [дансны дугаар бичих] дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
  - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
  - 3.2. Нийлүүлэгч тендер илгээсэн маягт;
  - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
  - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
  - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
  - 3.6. Техникийн тодорхойлолт;
  - 3.7. Бараа нийлүүлэлтийн хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
  - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:
  - 4.2. Нийлүүлэгчийн төлөөлөгчийн мэдээлэл  
Эцэг/эх-ийн нэр:  
Нэр:  
Албан тушаал:  
Ажлын утас:  
Гар утас:  
Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг] \_\_\_\_\_

## Гүйцэтгэлийн баталгааны маягт (Банкны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]** (цаашид “Нийлүүлэгч” гэх) нь **[бараа үйлчилгээний товч тодорхойлолт]**-ыг нийлүүлэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “гэрээ” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлүүлэх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Баталгаа гаргагч нь төлбөрийг тус мэдэгдэлд заасан дансанд үл маргах журмаар шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас төлүүлэх шаардлагын хэмжээ нь энэ баталгааны 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстай.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Банкны эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга, тэмдэг

Огноо:

Хаяг:

## Гүйцэтгэлийн баталгааны маягт

(Засгийн газрын бондын болон Засгийн газраас зөвшөөрсөн үнэт цаасны)

Баталгаа хүлээн авагч: **[Захиалагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

Огноо: **[баталгаа гаргасан огноог бичих]**

Дугаар: **[баталгааны дугаар бичих]**

Баталгаа гаргагч: **[хэвлэмэл хуудсанд бичигдээгүй бол баталгаа гаргагч байгууллагын нэр, хаягийг бичих]**

1. **[Нийлүүлэгчийн нэрийг бичих]** нь (цаашид “**Нийлүүлэгч**” гэх) **[бараа, үйлчилгээний төвч тодорхойлолт]**-ыг нийлүүлэх зорилгоор **[Гэрээний нэр ба дугаарыг бичих]** (цаашид “**гэрээ**” гэх)-ыг Баталгаа хүлээн авагчтай байгуулсан тухай мэдээллийг ирүүлээд байна.
2. Нийлүүлэгчийн хүсэлтээр Баталгаа гаргагч нь Баталгаа хүлээн авагчийн өмнө нийт **[мөнгөн дүн]**-ийн төлбөрийн үүрэг хүлээж **[баталгааны дүн тоогоор]** **[дүн үсгээр]** нэргэсэн үнэ бүхий **[Засгийн газрын бонд эсхүл үнэт цаасны нэр]** (цаашид “**Үнэт цаас**” гэх)<sup>8</sup> үндэслэн баталгаа гаргаж байна.
3. Нийлүүлэгч гэрээний үүргээ зөрчсөн тухай дурдаж төлбөр төлөх тухай захиалагчийн анхны шаардлагыг хүлээн авсан даруйд Үнэт цаасыг Захиалагчийн нэр дээр шилжүүлнэ.
4. Баталгаа гаргагчаас шилжүүлэх Үнэт цаасны нэргэсэн үнийн дүн нь 2-т заасан мөнгөн дүнгээс хэтрэхгүй ба энэ хүрээнд захиалагчийн шаардсан аливаа мөнгөн дүнд ямарваа нэгэн нотолгоо, үндэслэл болон тайлбар шаардахгүй.
5. Энэхүү баталгаа нь **[огноо бичих]** хүртэл хугацаанд хүчинтэй байх ба Захиалагч нь аливаа шаардлагыг энэ хугацаанд багтаж Баталгаа гаргагч талд мэдэгдэх ёстой.
6. Энэхүү баталгааг дээр дурдсанаас бусад үндэслэлээр хүчингүй болгосноос үүдэн гарах эрсдэлийг баталгаа гаргагч этгээд хариуцна.

**Баталгаа гаргасан,**

Эрх бүхий албан тушаалтны нэр:

Албан тушаалын нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг:

Байгууллагын тамга:

Огноо:

Хаяг:

<sup>8</sup> Засгийн газрын бондын болон үнэт цаасны эргэн төлөгдөх хугацаа нь гэрээний хэрэгжиж дуусах хугацаанаас 3-аас доoshгүй сарын дараа байна.

## A. ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо<sup>9</sup> : 2023-02-16

Тендер шалгаруулалтын нэр: СЭМҮТ-д Эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах  
Тендер шалгаруулалтын дугаар: СЭМҮТ/202209013

**Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь** эрх бүхий тендерт оролцогчдоос **тус төвд 2022 онд Эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж бодис** нийлүүлэх тухай битүүмжилсэн дахин нээлттэй тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдлээр нь **50,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтаас худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.  
Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** 2020, 2021 онуудын эм, эмнэлгийн хэрэгслийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас доошгүй байх

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** 2020, 2021 онуудын санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн хамт

**Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг:** 2020, 2021 он тус бүрийн ижил төстэй хэрэгжүүлсэн ажил нь оролцогчийн санал болгож буй тендерийн үнийн дүнгийн 70 хувиас багагүй байх

**Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм**

Тендерийн хамт багц тус бүрд доорх үнийн дүн бүхий, эсхүл түүнтэй тэнцүү чөлөөтэй хөрвөх валютын дүнтэй тендерийн баталгаа<sup>10</sup> ирүүлнэ.

|           | Багцын нэр   | Тендерийн баталгаа |
|-----------|--|--------------------|
| Багц №5   | Сэтгэц, зан үйлийн эмгэг, солиоролын эсрэг эм      | 290,191.00         |
| Багц №16  | Шүдний материал                                    | 21,400.00          |
| Багц № 17 | Шээсний "DIRUI H-100" анализаторын туузан оношлуур | 16,000.00          |
| Багц №18  | Иммунолгийн оношлуур                               | 23,500.00          |
| Багц №19  | Гематологийн уусмал "BCC-3600" анализатори         | 26,900.00          |

<sup>9</sup> Тендерийн урилгыг анх зарлан мэдээлсэн өдөр байна.

<sup>10</sup> Барааны төсөвт өртөг 30 сая төгрөгөөс дээш бол, тендерийн баталгаа ирүүлэхийг заавал шаардана.

|           |   |            |
|-----------|---|------------|
| Багц № 20 | "Gene xpert" анализаторын урвалж, оношлуур                                  | 64,000.00  |
| Багц №21  | Мансууруулах бодис болон сэтгэц идэвхит бодисыг илрүүлэх түргэвчилсэн сорил | 28,800.00  |
|           |   | 470,791.00 |

Тендерийг **2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 11 цаг 30 минутаас** өмнө [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2023 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн 12 цаг 00 минутад** Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвийн А байрны 204 тоот өрөөнд нээнэ.

- Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
  - Монгол улсын гарал үүсэлтэй бараанд 10%-ийн давуу эрх тооцно.
- Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Улаанбаатар хот, БЗД, 9-р хороо, 50-р гудамж, СЭМҮТ-н А блок 2 давхарт  
204 тоот, ЭМТҮЧАБА-ны дарга Д.Одончимэг, Утас: 99174249**

|     |                                      |                     |             |              |                  |                                   |  |                                    |
|-----|--------------------------------------|---------------------|-------------|--------------|------------------|-----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ | Эмийн хэлбэр | Савалттын хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг           | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                                      |                     |             |              |                  |                                   | 3 сар  |                                    |
| 1   | Арипипразол                          | 2400                | 12мг        | шахмал       | таб              | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б" блок | 2400   | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | Зопиклон                             | 900                 | 10мг        | шахмал       | таб              |                                   | 900  |                                    |
| 3   | Зуклопентиксол                       | 6000                | 50мг        | шахмал       | таб              |                                   | 6000   |                                    |
| 4   | Зуклопентиксол (Акуфаз)              | 400                 | 1мл\50      | т/уусмал     | амп              |                                   | 400  |                                    |
| 5   | Зуклопентиксол (Депо)                | 500                 | 1мл\200     | т/уусмал     | амп              |                                   | 500  |                                    |

Багц №16 Шүдний материал

|     |                                      |                     |             |              |                  |                                   |  |                                    |
|-----|--------------------------------------|---------------------|-------------|--------------|------------------|-----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Эмийн олон улсын буюу ерөнхий нэршил | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ | Эмийн хэлбэр | Савалттын хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг           | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                                      |                     |             |              |                  |                                   | 3 сар  |                                    |
| 1   | Апексметр                            | 1                   | ширхэг      |              | №1               | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б" блок | 1  | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | Наконечник ариутгач                  | 1                   | ширхэг      |              | №1               |                                   | 1  |                                    |
| 3   | Рентген зураг чиглүүлэгч             | 1                   | ширхэг      |              | №1               |                                   | 1  |                                    |
| 4   | Шүлс сорогч                          | 5                   | ширхэг      |              | №1               |                                   | 5  |                                    |

Багц № 17 Шээсний "DIRUI H-100" анализаторын түүзэн оношуулур

|     |                 |                     |             |  |              |                                   |  |                                    |
|-----|-----------------|---------------------|-------------|--|--------------|-----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Оношуулурын нэр | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ |  | Эмийн хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг           | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                 |                     |             |  |              |                                   | 3 сар  |                                    |
| 1   | DIRUI H-11      | 40                  | хайрцаг     |  | 100 тест     | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б" блок | 40   | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |

**Багц №18 Иммунологийн оношлуур**

|     |                          |                     |             |  |              |                                  |  |                                    |
|-----|--------------------------|---------------------|-------------|--|--------------|----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Оношлуурын нэр           | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ |  | Эмийн хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг          | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                          |                     |             |  |              |                                  | 3 сар  |                                    |
| 1   | H.Pylory Ag ётгөнд       | 100                 | ш           |  | Кассет       | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б"блок | 100  | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | Influenza A&B rapid test | 50                  | ш           |  | Кассет       |                                  | 50   |                                    |
| 3   | Витамин Д                | 2                   | кит         |  | 96 well      |                                  | 2  |                                    |

**Багц №19 Гематологийн уусмал "BCC-3600" анализатори**

|     |                    |                     |             |  |              |                                  |  |                                    |
|-----|--------------------|---------------------|-------------|--|--------------|----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Оношлуурын нэр     | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ |  | Эмийн хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг          | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                    |                     |             |  |              |                                  | 3 сар  |                                    |
| 1   | Гематологи Diluent | 5                   | хайрцаг     |  | 20л          | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б"блок | 5  | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | Гематологи Lyse    | 6                   | хайрцаг     |  | 500 мл       |                                  | 6  |                                    |
| 3   | 3 түвшний хяналт   | 1                   | хайрцаг     |  | 3*3 мл       |                                  | 1  |                                    |

**Багц № 20 "Gene xpert" анализаторын урвалж, оношлуур**

|     |                |                     |             |  |              |                                  |  |                                    |
|-----|----------------|---------------------|-------------|--|--------------|----------------------------------|--|------------------------------------|
| Д/д | Оношлуурын нэр | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ |  | Эмийн хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг          | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|     |                |                     |             |  |              |                                  | 3 сар  |                                    |
| 1   | HCV viral load | 40                  |             |  | №1           | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б"блок | 40   | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | HBV viral load | 40                  |             |  | №1           |                                  | 40   |                                    |

**Багц №21 Мансууруулах бодис болон сэтгэц идэвхит бодисыг илрүүлэх түргэвчилсэн сорил**

| Д/д | Оношлуурын нэр  | Захиалах тоо ширхэг | Тун, хэмжээ |  | Эмийн хэлбэр | Бараа хүргэх эцсийн цэг          | Захиалагч бараа хүлээн авах хугацаа (эхлэх болон дуусах хугацаа) | Нийлүүлэгчийн санал болгох хугацаа |
|-----|---|---------------------|-------------|--|--------------|----------------------------------|--|------------------------------------|
|     |   |                     |             |  |              |                                  | 3 сар  |                                    |
| 1   | Мансууруулах бодис болон сэтгэц идэвхит бодисыг илрүүлэх түргэвчилсэн сорил | 200                 | ш           |  | 1*25         | СЭМҮТ-ийн Эмзүйн агуулах "Б"блок | 200  | Нийлүүлэгчийн санал болгох хуваарь |
| 2   | Шээсний ариун сав   | 200                 | ш           |  | 60 мл        |                                  | 200  |                                    |